


ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 4/12

Мандалговь

“Дэрэн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”
зөвлөхийн үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон
шалгаруулах үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Дэрэн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” зөвлөхийн үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Э.Чагнаадорж (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга)

Гишүүд: Ю.Отгондэлгэр (Иргэний төлөөлөл)
Б.Пэрэнлэймаа (Аймгийн засаг даргын тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

Б.Сэргжмядаг (Аймгийн засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичиг: М.Бат-Эрдэнэ (Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Э.Чагнаадорж)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (М.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  И.ДОРЖBAT
Л.ДОРЖБАТ

4822150010